



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/558

Улаанбаатар хот

“Улсын хоёрдугаар төв эмнэлэг”-ийн  
дүрэм бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан төсөвт багтаан дүрэм, бүтцийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирал С.Энхболдод үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/564 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

141202304

Эрүүл мэндийн сайдын  
2020 оны 16 сарын 01 өдрийн 41 тушаалын  
нэгдүгээр хавсралт 558

## УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ДҮРЭМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Улсын хоёрдугаар төв эмнэлэг (цаашид эмнэлэг гэх) нь улсын хэмжээнд дүрс оношилгоо, цөмийн оношилгоо, эмчилгээ, лаборатори, дурангийн оношилгоо, эмчилгээ, дурангийн мэс заслын төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангах, үйлчлэх хүрээний хүн амд эмнэлгийн мэргэшсэн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг мөн.
- 1.2 Эмнэлэг нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, “Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6330:2017” Монгол Улсын стандарт болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 1.3 Эмнэлгийн оноосон нэрийг “Улсын хоёрдугаар төв эмнэлэг” гэх бөгөөд англи хэл дээр “Second State Central Hospital” гэж орчуулна.
- 1.4 Эмнэлэг нь тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харилцааны данс, өөрийн бэлгэдэлтэй байна.
- 1.5 Эмнэлгийн бэлгэдлийг (лого) албан бичгийн хэвлэмэл хуудасны толгойд, мөн байгууллагын туган дээр албан ёсоор тавина.
- 1.6 Энэ дүрмийн 1.4-д заасан тамга, тэмдгээр эмнэлгийн албан ёсны шийдвэр, албан, гэрээ, хэлцлийг тамга тэмдгээр баталгаажуулна. Эмнэлгийн захирлын томилсон албан тушаалтан тамга, тэмдгийг түшнэ.
- 1.7 Эмнэлэг нь Улаанбаатар хотод байрлаж дараах хаягт үйл ажиллагаа явуулна. Үүнд:  
Байгууллагын хаяг: Энхтайвны өргөн чөлөө-17, Баянзүрх дүүрэг, 3-р хороо,  
Шуудангийн хаяг: 210349 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайваны  
өргөн чөлөө-49,  
Утас:976 70150308, Факс: 976 70150200  
Цахим хаяг: [www.ssch.gov.mn](http://www.ssch.gov.mn)

## ХОЁР. ЭМНЭЛГИЙН ҮНДСЭН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

### 2.1 Эмнэлгийн алсын хараа:

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, Монгол Улсын шилдэг эмнэлэг болно.

### 2.2 Эрхэм зорилго:

Ард иргэдийн хүсэл хэрэгцээг хангахуйц, чанартай, аюулгүй тусламж, үйлчилгээтэй шилдэг эмнэлэг байна.

### 2.3 Эмнэлгийн зорилт:

1. Чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлнэ.
2. Эмчилгээ, оношилгооны дэвшилтэт технологийг үйл ажиллагаандаа өргөнөөр ашиглана.
3. Цөмийн онош зүйн шинэ технологийг нэвтрүүлнэ.
4. Үндэсний болон олон улсын хэмжээнд алсын зайн оношилгоо, эмчилгээний төв болно.

### 2.4 Эмнэлгийн зарчим:

- Үйлчлүүлэгчийг дээдлэх;
- Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах;
- Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн, нууцлалыг сахих;
- Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах;
- Тусламж, үйлчилгээтэй холбоотой шийдвэрийг нотолгоонд суурилан гаргах;
- Тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчид чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах;
- Ил тод, нээлттэй байж үйлчлүүлэгчийг шаардлагатай мэдээллээр хангах;
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх;

### 2.5 Эмнэлгийн уриа:

Хүний төлөө  
Хүчирхэг баг

### 2.6 Эмнэлгийн үнэт зүйлс:

- Шинийг бүтээгч
- Багийн хамтын ажиллагаа
- Ёс зүйтэй эмч, мэргэжилтнүүд
- Хүндэтгэлтэй харьцаа

ГУРАВ. ЭМНЭЛГИЙН ЭРХ, ҮҮРЭГ

### 3.1. Эмнэлэг нь дараах эрхтэй:

- 3.1.1. Эмнэлгийн үзүүлж буй тусламж, үйлчилгээний чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм, стандарт, эмнэл зүйн удирдамжтай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- 3.1.2. Эмнэлэг нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэц, хүний нөөц, материалаг нөөц, төсвийг бүрдүүлж зохих хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу захиран зарцуулах;

- 3.1.3. Эмнэлгийн төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээтэй ижил үүрэг бүхий гадаадын эмнэлгүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн, тусламж, үйлчилгээг сайжруулах, байгууллага болон хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцан туршлага солилцох;
- 3.1.4. Судалгаа, шинжилгээг хөгжүүлэн, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах;
- 3.1.5. Төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх асуудлаар гэрээ байгуулах, харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулах;
- 3.1.6. Гадаадын эрүүл мэндийн байгууллага, олон улсын байгууллагаас мэргэжилтэн, зочид, төлөөлөгч урин хамтран ажиллах;
- 3.1.7. Эмнэлэг нь тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал боловсруулан тавьж шийдвэрлүүлэх;
- 3.1.8. Эмнэлэг нь хууль, тогтоомж, төрийн байгууллагын төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн дагуу тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;
- 3.1.9. Хууль, тогтоомжоор олгогдсон бусад эрх;

### **3.2. Эмнэлэг нь дараах үүрэгтэй:**

- 3.2.1. Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан нутаг дэвсгэрийн харъяаллаар үйлчлэх хүн ам, төрийн улс төрийн болон төрийн өндөр албан тушаалтан, бусад албан тушаалтанд эмнэлгийн анхан шатлалын, үндсэн мэргэжлийн тусламжийг, зарим төрөлжсөн мэргэшлийн лавлагаа тусламж, үйлчилгээг улсын хэмжээнд холбогдох стандарт, журам, зааврын дагуу үзүүлэх;
- 3.2.2. Эмнэлэг нь үзүүлж буй тусламж, үйлчилгээний чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, эмчилгээний зөвлөмж, дүгнэлт гаргах;
- 3.2.3. Эмнэлгийн үзүүлж буй тусламж, үйлчилгээг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний саналыг боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;
- 3.2.4. Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамж, аргачлал боловсруулах;
- 3.2.5. Төрөлжсөн тусламж, үйлчилгээний чиглэлээр төгсөлтийн дараах албан ба албан бус сургалтыг зохион байгуулах, улсын хэмжээнд мэргэжил арга зүйгээр хангах мэргэшлийн чиглэлээр бусад эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн баг ажиллуулан, ажлын байрны болон зайн сургалт явуулах;
- 3.2.6. Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах үүднээс зардлын хувьд үр ашигтай оношилгоо, эмчилгээний дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлэх;
- 3.2.7. Үйлчлэх хүрээний болон зорилтот бүлгийн хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах, холбогдох байгууллагыг арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах;
- 3.2.8. Эмнэлгийн үйлчлэх хүрээний хүн амын дундах өвчлөлийн түвшин, тархалт, нас баралтыг судлах тандалтын тогтолцоог бий болгон мэдээний сан бүрдүүлж, төрийн захиргааны төв байгууллага, хүн ам, бусад холбогдох этгээдийг мэдээллээр хангах;
- 3.2.9. Эмнэлэг нь үйлчлүүлэгчийг тусламж, үйлчилгээний шууд төлбөрөөс шалтгаалж ядууралд орохоос сэргийлэхэд чиглэгдсэн үнийн бодлогыг баримталж, орлого

- багатай үйлчлүүлэгчдэд зориулсан хөнгөлөлт, санхүүгийн дэмжлэг арга хэмжээг аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;
- 3.2.10. Үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн, цахим эмнэлэг, цахим бүртгэл, цахим өвчний түүхийг ашиглах нөхцлийг бүрдүүлэх, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх;
- 3.2.11. Эмнэлэг нь үзүүлж буй тусламж, үйлчилгээний чиглэлээр орлогоо нэмэгдүүлэх зорилгоор зохиомол эрэлт бий болгохоос сэргийлж эмнэлзүйн судалгаа шинжилгээг гүйцэтгэж, оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамжийг боловсронгуй болгоход шаардлагатай нотолгоог бий болгох;
- 3.2.12. Эмнэлэг нь төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хүрээнд алсын хараа, хэтийн зорилгоо тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, байгууллагын хөгжлийн хөтөлбөр, байгууллагын дотоод журам, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хөтөлбөр, эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр, хүний нөөцийн төлөвлөгөө, боловсруулж, хэрэгжүүлэн ажиллах,;
- 3.2.13. Эмнэлэг нь үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн болон өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах;
- 3.2.14. Эмнэлэг хооронд зөвөрлөх боломжгүй, эсхүл тусгай хамгаалалттай нөхцөлд эмчлүүлж буй үйлчлүүлэгчдэд явуулын амбулатори, цахим зөвлөгөө, телемедициний сүлжээг ашиглан төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй шуурхай хүргэх;
- 3.2.15. Эмнэлэг нь тусламж, үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авч шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, ирсэн санал, гомдолд дүн шинжилгээ хийж залруулах, арга хэмжээг үйл ажиллагаандаа тусган ажиллах;
- 3.2.16. Эмнэлэг нь өөрийн үзүүлж буй тусламж, үйлчилгээний чиглэлээр болон байгууллагын үйл ажиллагаанд олон улсын түвшний итгэмжлэл авсан байх;
- 3.2.17. Эмнэлэг нь санхүү төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан, санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит болон нотолгоонд тулгаарласан байдлыг хангаж, үр дүнгийн хувьд ижил бол эдийн засгийн хувьд үр ашигтайг нь сонгон санхүүжүүлдэг байх;
- 3.2.18. Эмнэлэг нь өөрийн үйл ажиллагаандаа тусламж, үйлчилгээний онцлогийг тусгасан эрсдлийн удирдлагын журам боловсруулан, хэрэгжүүлэх;
- 3.2.19. Эмнэлэг нь ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцлийг сайжруулах талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах;
- 3.2.20. Эмнэлэг нь улсын хэмжээнд мөрдөх эрх зүйн баримт бичгийг боловсруулахдаа төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, мэргэжлийн салбар зөвлөлийн оролцоог бүрэн хангаж ажиллах;
- 3.2.21. Эмнэлэг нь ажиллагсдын мэдлэг, ур чадварыг байнга дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, сахилга, хариуцлагын хэм хэмжээг мөрдүүлж ажиллах;
- 3.2.22. Хууль, тогтоомжоор олгогдсон бусад үүрэг;

#### ДӨРӨВ. ЭМНЭЛГИЙН УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮН, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

- 4.1.1 Эмнэлгийн удирдлагын тогтолцоо нь Эмнэлгийн ерөнхий захирал, түүний дэргэдэх Удирдлагын зөвлөлөөс бүрдэнэ.
- 4.1.2 Эмнэлгийн ерөнхий захирал нь Эмнэлзүй хариуцсан дэд захирал, Эрдэм шинжилгээ, инноваци, хөгжлийн бодлого хариуцсан дэд захирал, Төлөвлөлт, эдийн засаг,

маркетинг хариуцсан дэд захирал болон алба, төв, тасгийн удирдлагаас бүрдсэн Удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг батална.

- 4.1.3 Эмнэлэг нь судалгаа, шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгаа шинжилгээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээний сэдэв, арга зүй, явц, үр дүнг хэлэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт гаргах үүрэг бүхий албан бус орон тооны Эрдмийн зөвлөл байгуулан ажиллана. Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Эмнэлгийн ерөнхий захирал батална.
- 4.1.4 Эмнэлгийн ерөнхий захирал тушаал, Удирдлагын зөвлөл болон Эрдмийн зөвлөл нь хурлын тэмдэглэл гаргана.
- 4.1.5 Эмнэлэг нь дэргэдээ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Эмийн эмчилгээг зохицуулах хороо, Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөл, Халдвар хяналтын алба, Эмчилгээний хоолны зөвлөл, Санал, гомдлын хороо зэрэг албан бус орон тооны хороог байгуулан ажиллана.
- 4.1.6 Эмнэлэг нь тусламж, үйлчилгээ үзүүлэх алба, төв, тасаг, нэгжийн чиг үүргийг тодорхойлж өөрийн онцлогт тохируулан эмнэлгийн бүтцийг зохион байгуулна.
- 4.1. Эмнэлэг нь холбогдох хууль, тогтоомж, тушаал, шийдвэрийн хүрээнд хүүхдийн цэцэрлэг, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын нөхцөл сайжруулах, бусад дэмжих үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлж болно.

#### 4.2. ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.2.1. Эмнэлгийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг нь хариуцах;
- 4.2.2. Байгууллагын дотоод журмыг батлан хэрэгжүүлэх, эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 4.2.3. Эмнэлгийн удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зөвлөх, хамтын шийдвэр гаргах Удирдлагын зөвлөлийг байгуулж, түүний ажиллах журмыг батлан хэрэгжүүлнэ.
- 4.2.4. Эмнэлзүй хариуцсан дэд захирал, Эрдэм шинжилгээ, инноваци, хөгжлийн бодлого хариуцсан дэд захирал, Төлөвлөлт, эдийн засаг, маркетинг хариуцсан дэд захирал, төв, тасаг, албадын дарга нарын үндсэн чиг үүргийг тогтоох, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны албан тушаалын тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд авч, хөдөлмөрийн гэрээ байгуулах, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлж, хөдөлмөрийн гэрээ цуцлах, дуусгавар болгоно.
- 4.2.5. Эмнэлзүй хариуцсан дэд захирал, Эрдэм шинжилгээ, инноваци, хөгжлийн бодлого хариуцсан дэд захирал, Төлөвлөлт, эдийн засаг, маркетинг хариуцсан дэд захирал, алба, төв, тасаг, нэгжийн дарга, эрхлэгч бусад эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг сонгон шалгаруулж ажилд авах, шилжүүлэн ажиллуулах, чөлөөлөх;
- 4.2.6. Эмнэлгийн бүтцийн нэгжийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, байгууллагын дотоод журам, ойрын болон хэтийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэнд нь хяналт тавих;
- 4.2.7. Эмнэлгийн тухайн жилийн батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан эмнэлгийн орон тоо, ажиллагсдын цалин, нэмэгдэл, хөлсийг тогтоох;
- 4.2.8. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийн тайланг байгууллагын хамт олны хурлаар хэлэлцүүлэн, мэдээлэх;
- 4.2.9. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны албан тушаалын тодорхойлолтыг батлан, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, албан тушаал бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, шагнах, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, хөдөлмөрийн гэрээг цуцлах;
- 4.2.10. Төсвийн ерөнхийлөн захирагчаар жил бүр эмнэлгийн гүйцэтгэлийн төлөвлөө батлуулж, биелэлтийг ханган ажиллаж, тайлагнах;

- 4.2.11. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэн зөв байдлыг хариуцах;
- 4.2.12. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авлигаас ангид ажиллах;

#### ТАВ. ЭМНЭЛГИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

5.1 Эмнэлгийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- 5.1.1. Улсын төсөв;
  - 5.1.2. Эрүүл мэндийн даатгал;
  - 5.1.3. Үндсэн төлбөрт (төлбөрт тусламж, үйлчилгээний орлого, үйлчлүүлэгчийн захиалгаар хийх урьдчилан сэргийлэх үзлэг) ба үндсэн бус үйл ажиллагааны орлого (хууль, тогтоомжид нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж олсон ашиг, орлого гэх мэт);
  - 5.1.4. Төсвийн тухай хуулинд заасны дагуу Монгол улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүнээс авсан хандив, тусламж;
  - 5.1.5. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
  - 5.1.6. Хууль, тогтоомжид заасан бусад эх үүсвэр.
- 5.2. Эмнэлэг нь бие даасан данс, эд хөрөнгөтэй байна.
- 5.3. Эмнэлэг нь төсөв, санхүүгийн удирдлагын үр ашигтай менежментийг нутагшуулж, төсөв санхүүгийн эрсдэлийг бүрэн тооцож, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах, үр дүнгийн гэрээний гүйцэтгэл, үр дүнд суурилсан урамшууллын тогтолцоог нэвтрүүлж ажиллана.
- 5.4. Эмнэлэг нь санхүүжилт, эд хөрөнгийг эмнэлгийн үндсэн зорилго, холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулж, ашиглана.
- 5.5. Эмнэлэг нь өөрийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үндсэн хөрөнгө олж авах, тэдгээрийг данснаас хасах, шилжүүлэх, актлах саналаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 5.6. Эмнэлгийн эд хөрөнгийн тооллогыг Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тогтоосон хугацаанд, холбогдох журмын дагуу явуулна.
- 5.7. Эмнэлэг нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гүйцэтгэж, аудит хийлгэнэ.
- 5.8. Эмнэлэг нь өөрийн эд хөрөнгө, санхүү, нягтлан бодох бүртгэл, тооцоонд тавих дотоодын болон хөндлөнгийн хяналтыг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

#### ЗУРГАА. ЭМНЭЛГИЙН ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- 6.1 Эмнэлгийг гадаад, дотоодын хамтын ажиллагаанд эмнэлгийн ерөнхий захирал төлөөлнө.
- 6.2 Эмнэлгийн даргын гадаад оронд туршлага судлах, мэргэжлийн сургалтанд суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ.
- 6.3 Эмнэлгийн ажилтны гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, суралцах асуудлыг эмнэлгийн ерөнхий захирал шийдвэрлэнэ.
- 6.4 Эмнэлэг нь Төрийн захиргааны төв байгууллагын удирдлагууд, газрын дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль, тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг, зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.
- 6.5 Эмнэлэг нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

ДОЛОО. ЭМНЭЛГИЙН МЭРГЭШСЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ  
БҮТЦИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ


7.1 Эмнэлзүйн тасгийн бүтэц, үйл ажиллагаа

Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан үйлчлэх хүн ам болон тус эмнэлгийг сонгон үйлчлүүлж буй иргэдэд дараах эмнэл зүйн тасгууд нь эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

- 7.1.1 Дүрс оношилгооны төвд 2 тасаг харъяалагдаж, тухайн чиглэлээр тусламж, үйлчилгээ үзүүлнэ. Төвийн даргын удирдлагад тасгийн эрхлэгч нар харъяалагдана.
  - 7.1.1.1 Радиологийн тасаг
  - 7.1.1.2 Ангиографийн тасаг
- 7.1.2 Дурангийн төв
- 7.1.3 Цөмийн оношилгоо, эмчилгээний төв
- 7.1.4 Амбулатори
  - 7.1.4.1 Эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх төв
  - 7.1.4.2 Цахим бүртгэл
  - 7.1.4.3 Төрөлжсөн мэргэшлийн кабинетууд
- 7.1.5 Нэгдсэн лабораторийн тасаг
  - 7.1.5.1 Биохимийн лаборатори
  - 7.1.5.2 Гематологийн лаборатори
  - 7.1.5.3 Дархлаа судлалын лаборатори
  - 7.1.5.4 Клиник-химийн лаборатори
  - 7.1.5.5 Молекул-биологийн лаборатори
  - 7.1.5.6 Иммуно-гематологийн лаборатори
  - 7.1.5.7 Нян судлалын лаборатори
  - 7.1.5.8 Эмгэг судлалын лаборатори
- 7.1.6 Бөөр, дотоод шүүрэл судлалын төв
  - 7.1.6.1 Бөөр, дотоод шүүрлийн тасаг,
  - 7.1.6.2 Диабетын нэгж
  - 7.1.6.3 Гемодиализын нэгж
- 7.1.7 Зүрх судас судлалын тасаг
- 7.1.8 Уушги судлалын тасаг
- 7.1.9 Хоол боловсруулах эрхтэн судлалын тасаг
- 7.1.10 Тусгай тасаг
- 7.1.11 Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасаг
- 7.1.12 Ерөнхий мэс заслын тасаг
- 7.1.13 Бөөрний мэс заслын тасаг
- 7.1.14 Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг
- 7.1.15 Гэмтэл согог, ортопедийн тасаг
- 7.1.16 Мэдрэлийн мэс заслын тасаг
- 7.1.17 Толгой хүзүү, Чих, хамар хоолойн нөхөн сэргээх мэс заслын тасаг
- 7.1.18 Нүд судлалын тасаг
- 7.1.19 Яаралтай тусламжийн тасаг
- 7.1.20 Мэдрэл судлалын тасаг
- 7.1.21 Хүүхдийн тасаг
- 7.1.22 Уламжлалт эмчилгээний тасаг
- 7.1.23 Сэргээн засах эмчилгээний тасаг



- 7.1.24 Ариутгал, халдваргүйтлийн тасаг  
 7.1.25 Сувилахуйн алба  
 7.1.26 Эмнэл зүйн зохицуулалтын алба
- 7.2 **Сувилахуйн алба:** Сувилахуйн алба нь олон улсын стандарт шаардлагад нийцсэн үйлчлүүлэгч төвтэй, аюулгүй сувилахуйн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх үндсэн үүрэгтэй.
- 7.3 **Эмнэл зүйн зохицуулалтын алба:** Байгууллагын хэмжээнд статистик мэдээ, мэдээллийг цуглуулах, бүртгэх, мэдээлэх, дамжуулах, тайлагнах, мэдээний сан үүсгэх үйл ажиллагааг хариуцах, сургалт хийх, бүртгэл мэдээллийн байдалд хяналт тавих, цахим бүртгэл, бодит мэдээллийг нэвтрүүлэх, Эрүүл мэндийн даатгал талаар төрөөс гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, сурталчлах, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах, эрүүл мэндийн даатгалын гэрээний гүйцэтгэлийг хянах, үйл ажиллагааг удирдлагын өмнө тайлагнах, сургалт явуулах, Эрүүл мэндийн даатгалтай холбоотой асуудлаар санал боловсруулна.
- 7.4 Эмнэлэг нь холбогдох журмын дагуу улсын хэмжээнд бусад эрүүл мэндийн байгууллагыг арга зүйгээр хангах чиг үүргийг дараах хүрээнд хэрэгжүүлнэ.



НАЙМ. ЭМНЭЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ  
 БҮТЦИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ

- 8.1 **Сургалт, гадаад харилцааны алба:** Тухайн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил эрхлэх, судалгааны дүн, зөвлөмж боловсруулах, судалгааны чиглэлээр мэдээний сан

үүсгэх, төгсөлтийн дараахь сургалтуудыг (резидентийн болон мэргэшүүлэх, дээшлүүлэх) эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулж явуулах, эрдэм шинжилгээний сургалт, семинарыг зохион байгуулна.

Байгууллагын хөгжил, эмчилгээ оношлогооны дэвшилтэт арга технологийн чиглэлээр гадаад харилцааг өргөжүүлэн олон улсын байгууллагатай хамтран ажиллах төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллах, олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинарт оролцох ажлыг зохион байгуулах, өөрийн оронд зохион байгуулах, түүнд холбогдох хүмүүсийг оролцуулах, олон улсад нэвтэрч буй анагаах ухааны ололт амжилтыг нэвтрүүлэх санал, зөвлөмж боловсруулах, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулах, шинэ оношилгоо, эмчилгээний аргыг өөрийн оронд нутагшуулах талаар судалгаа хийнэ.

Байгууллагын гадаад харилцааг бэхжүүлж олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, төсөл хөтөлбөрүүдэд хамрагдаж хүний нөөцийн хөгжил болон стратеги, төлөвлөлтөнд тодорхой байр суурь илэрхийлж оролцох чиг үүрэгтэй ажиллана.

**8.2 Мэдээлэл технологийн алба:** Байгууллагын компьютер, техник хэрэгсэл болон гадаад, дотоод сүлжээ, мэдээлэл, холбооны хэрэгслийн үйл ажиллагааны тогтвортой, аюулгүй байдлыг хангах, хянах, хөгжүүлэх, байгууллагын цахим хуудасны шинэчлэл, баяжилтыг хийх, мэдээллийн технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, алсын зайн оношлогоог хөгжүүлэх, эмнэлгийн ажилтнуудад мэдээллийн технологийн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.

**8.3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба:** Эмнэлгийн хэмжээнд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийг хүлээн авах, суурилуулах, үйл ажиллагаанд оруулах, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, үзлэг, үйлчилгээ хийх, холбогдох маягт, баримт бичгүүдийг стандартын дагуу хөтөлж, тоног төхөөрөмжийн хангамж, цаашдын шаардлагыг тодорхойлж мэдээллээр удирдлагыг ханган ажиллана. Ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн байнгын, хэвийн, найдвартай ажиллагааг хангах, нэгдсэн мэдээллийн цахим санд эмнэлгийн мэдээллийг оруулан тогтмол хөтлөхөөс гадна шаардлагатай сэлбэг, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн захиалга хийх, үзлэг, засвар, үйлчилгээ хийхдээ тухайн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс ирүүлсэн техникийн бичиг баримт, мөрдөгдөж буй стандарт, удирдамжуудыг мөрдөж ажиллах, тоног төхөөрөмжтэй харьцан ажилладаг эмч, мэргэжилтэн, ажилтанд мэргэжлийн зөвлөгөө өгөх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалт явуулах зэрэг үйл ажиллагаа явуулна. Монгол Улсад анх удаа суурилагдаж байгаа ПЕТ/СТ, циклотроны үйлдвэр, түүний лабораторийн тоног төхөөрөмжийн аюулгүй, хэвийн үйл ажиллагааг хариуцан холбогдох төв, тасагтай хамтран ажиллана.

**8.4 Нийгмийн эрүүл мэнд, тандалтын алба:** Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан үйлчлэх хүн амын дунд зонхилон тохиолдох халдвар бус өвчний тандалт, судалгаа хийж, хянана. Хүн амын эрүүл мэндийн талаарх хэрэгцээ, дадал, хандлагыг судлан тандах, хүн ам, олон нийттэй харилцах үйл ажиллагаа, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, эрүүл зан үйл, аж төрөх ёсыг хэвшүүлэхэд чиглэсэн тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулах, бусад салбарыг эдгээр үйл ажиллагаанд татан оролцуулах, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудтай хамтран эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, инфографик, нэвтрүүлэг, сурвалжлага бэлтгэх, нийтлэн түгээнэ. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт, биелэлтийг хариуцаж нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

**8.5 Алсын зайн оношилгооны хэсэг:** Эмнэлгийн лавлагаа тусламж, үйлчилгээг бусад шатлалын эмнэлгүүдэд зайн дамжуулах технологид тулгуурлан үзүүлэх, өндөр хөгжилтэй орнуудын хамтын ажиллагаатай эмнэлгүүдтэй зайн оношлогооны тусламжтайгаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, санал солилцоно.

**8.6 Эдийн засаг, төлөвлөлтийн алба:** Байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд шаардагдах хөрөнгө болон үйл ажиллагааг холбогдох хууль эрхзүйн хүрээнд зохицуулан төлөвлөх, хөрөнгө зарцуулалтын үр ашигтай, зохистой байдал, хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтэнд үнэлгээ хийх, удирдлагыг мэдээллээр хангана.

**8.7 Инженерийн байгууламжийн алба:** Эмнэлгийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, өргөх механизм цахилгаан шат, цахилгааны хангамж, гэрэлтүүлэг болон галын аюулгүй байдал, агаар сэлгэлт, дулаан, сантехникийн засвар үйлчилгээг албаны чиг үүргийн хүрээнд батлагдсан стандартын дагуу мэргэжлийн техникийн тусламж, үйлчилгээ засварыг хийж, засвар, үйлчилгээний холбогдолтой мэдээллийн сан байгуулж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, техникийн аюулгүй байдал, жигд хэвийн үйл ажиллагааг ханган ажиллана.

**8.8 Аж ахуй, үйлчилгээний алба:** Байгууллагын барилга, эд хогшлийн засвар үйлчилгээг хийх, засвар үйлчилгээний холбогдолтой мэдээллийн сан байгуулж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, тоног төхөөрөмж ашиглаж ажилладаг тасаг, хэсгүүдийн аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэх ажлыг зохон байгуулах, гадаад болон дотоод орчны тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээг хийх, байгууллагын түргэн тусламжийн автомашин, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангаж тусламж, үйлчилгээг тасалдуулахгүй ажиллах, байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг тус тус хангаж ажиллана.

**8.9 Хоол шим тэжээлийн тасаг:** Монгол Улсын Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хууль, MNS CAC/RCP 1:2003 "Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим", MNS CAC/RCP 39:2011 "Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал" стандарт, Хоол эмчилгээний удирдамж, Зонхилон тохиолдох өвчний үеийн хоолны стандарт болон бусад хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн хоол үйлдвэрлэлийн шат дамжлага бүрт аюулын дүн шинжилгээ хийж үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэн, аюул эрсдлийг залруулах замаар үйлчлүүлэгчдэд баталгаатай эрүүл хүнсээр хангах, үйлчлүүлэгчдийн эмчилгээний хоол болон эмнэлгийн ажилтнуудад өдрийн хоол, жижүүр эмч, ээлжийн ажилчдад өглөөний цай болон оройн хоолыг батлагдсан технологийн дагуу үйлдвэрлэнэ.

**8.10 Эм зүйн хангамжийн алба:** Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд эмийн эмчилгээний үр дүнг хянаж, чанар аюулгүй байдлыг хангаж ажиллахын зэрэгцээ эмчилгээний өндөр идэвхитэй, аюулгүй, чанарын баталгаатай эмээр тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангаж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлж ажиллана.

## ЕС. ЭМНЭЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ УДИРДАХ, ХЯНАХ БҮТЦИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ

**9.1 Захиргаа, хүний нөөцийн алба:** Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдэлтийг хангах, хүний нөөцийн ил тод байдлыг ханган ажиллах, салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, стратеги, хөтөлбөр, хууль, журам, тушаал, бусад шийдвэрийн хэрэгжилтийг байгууллагын түвшинд зохион байгуулах, байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тооцож, төлөвлөх, бүрдүүлэх, сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх, хангалт, хуваарилалт, байршуулалт хийх, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж батлуулах, ажил үүргийн хуваарилалтад үнэлгээ хийх, байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны тасралтгүй сургах, чадавхижуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, багц цагийн баталгаажуулалт хийх, ажилтны хувийн хэрэг, мэдээний санг хөтлөх, тогтмол баяжилт хийх, ажилтантай үр дүнгийн гэрээ байгуулах, үнэлж дүгнэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна байгууллагын хүний нөөцийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж, албан хаагчтай холбоотой шийдвэр гаргахад удирдлагад дэмжлэг үзүүлэх, ажилтны нийгмийн баталгааг хангах болон цалин, урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлыг шийдвэрлүүлнэ. Архив, бичиг хэрэг, захиргааны албаны үйл ажиллагааг эрхлэнэ. Эмнэлгийн захиргааны холбогдолтой баримт бичиг, заавар, дүрэм, журам боловсруулах, хянах, батлуулна. Удирдах ажилтны хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулна.

**9.2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба:** Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах, чанар, аюулгүй байдал мөн цацрагийн аюулгүй байдалд дотоодын хяналт тавих, үнэлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийг мөрдүүлэн, тусламж, үйлчилгээний чанарын мэдээллийн сан байгуулах, үйлчлүүлэгч болон ажилтны дунд сэтгэл ханамжийн судалгаа явуулж үр дүнг тооцон ажиллах, хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх аудит, мэргэжлийн хяналтын шалгалт, магадлан итгэмжлэл, хөндлөнгийн хяналт-шинжилгээний бэлтгэл, үйл ажиллагааг зохион байгуулах, үнэлгээ, дүн, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, дотоод хяналтын алба-төв эмнэлгийн удирдлагын тогтолцооны дэргэд орон тооны байдлаар зохион байгуулагдан ажиллах ба байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх, эмнэлзүйн эрсдэлийн бэлэн байдлыг үнэлэх, шаардлагатай үед байгууллагын тодорхой чиг үүрэгт системчилсэн үнэлгээ хийх, хөрөнгө зарцуулалтын үр ашигтай зохистой байдал, хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийн талаар үнэлгээ хийх, хяналт шинжилгээний дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагаа сайжруулах зөвлөмж гаргана.

**9.3 Санхүү, бүртгэлийн алба:** Байгууллагын нягтлан бодох, бүртгэлийг Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж байгаа Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудын заалтад нийцсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан тэнцэл, урсгал төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд гаргах, харилцагч, хэрэглэгч, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, эд хөрөнгөд бүртгэлээр хяналт тавьж ажиллана.

### **АРАВ. ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

- 10.1 Эмнэлгийн ерөнхий захирлын саналыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулна
- 10.2 Энэхүү дүрэмд тусгагдсанаас бусад асуудлыг холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгээр зохицуулна.

2020 оны 11 сарын 27-ны өдөр ЭРХ ТУШААЛЫН  
 хоёрдугаар хавсралт 558

## УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН БҮТЭЦ

